

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ ОРОН НУТАГТ ТӨЛӨӨЛӨН
2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ ХҮРЭЭНД БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗАР ХАМТРАН
АЖИЛЛАХ 24-10 ТООТ ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2024 оны 11 сарын 22

Мандалговь хот

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Байгаль орчны газрын сайд, аймгийн Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэлийн үр дүнг хянах, үнэлэх, дүгнэлт зөвлөмж гаргах, үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналтыг сайжруулж, цаашид гарах үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэхэд оршино.

ХОЁР.ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Байгаль орчны газрын сайдтай байгуулсан аймгийн Засаг даргын хамтран ажиллах гэрээний 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2-т заасан арга зүйгээр Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсээс ирүүлсэн тайланд үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Байгаль орчны газрын сайдтай аймгийн Засаг даргын байгуулсан хамтран ажиллах гэрээний 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж хэрэгжилт удаашралтай арга хэмжээний жагсаалтыг гарган холбогдох хэлтэст хүргүүлэн цаашид анхаарах асуудал дээр зөвлөмж өгч ажилласан.


ГУРАВ.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Байгаль орчин, аялал жуулчлалын салбарт 2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 8 зорилтын хүрээнд ажил тусган хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Эхний хагас жилийн хэрэгжилтэд явцын хяналт шинжилгээ хийхэд 91 хувьтай байсан ба жилийн эцсийн байдлаар 98.4 хувьтай хэрэгжүүлсэн байна. 2024 оны улсын төсвөөр хэрэгжүүлсэн байна.

Нийт 45 арга хэмжээ хэрэгжүүлэхээс 42 арга хэмжээ 100 хувь, 95 хувь – 1, 70 хувь-1, 61.7 хувь-1 хэрэгжсэн байна. Гэрээгээр хүлээсэн арга хэмжээг хэрэгжүүлэхийн тулд улсын төсвийн 429 сая.төгрөг, орон нутгийн төсвийн 518.7 сая.төгрөг, хувийн хэвшлийн 935.1 сая.төгрөг, байгаль хамгаалах сангийн 111.7 сая.төгрөг нийт 1994.5 сая төгрөгийг дээрх арга хэмжээнүүдэд зарцуулсан байна. Гэрээгээр хүлээсэн арга хэмжээнүүдээс дараах арга хэмжээнүүд үр дүнтэй хэрэгжсэн гэж үзэж байна.

Гэрээний хэрэгжилтийг жилийн эцсийн байдлаар зорилт тус бүрээр харуулбал:

№	Зорилтын нэр	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн хувь
1.	Байгаль орчны багц хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд (Салбарын хяналт, хяналт шалгалттай холбоотой асуудлыг оруулах)	5	100
2.	Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний хүрээнд	5	92
3.	Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, бохирдол багатай ногоон хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хангах хүрээнд	6	100
4.	Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийг хамгаалах хүрээнд (цөлжилт, амьтан, ургамал, хог, хөрс, нөхөн сэргээлт гэх мэт бичих)	13	97
5.	Усны нөөцийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах хүрээнд	4	100
6.	Ойн нөөцийг ашиглалт, хамгаалалт, “Тэрбум мод” хөдөлгөөнийг өрнүүлж, зорилтын хэрэгжилтийг хангах хүрээнд	4	100
7.	Аялал жуулчлалыг хөгжүүлэх хүрээнд	6	100
8.	Тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах хүрээнд	2	100
Дүн		45	98,4



ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖСЭН ОНЦЛОХ АЖЛУУД:

Зорилт:1 Байгаль орчны багц хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд

1.2 дахь арга хэмжээ. Байгаль орчны салбарын хууль тогтоомжоор сургалт, сурталчилгаа зохион байгуулах

Мод тарих чиглэлийн сургалтад 1387 иргэн, хог хаягдлын чиглэлээр сургалтад 631 иргэн, үзэсгэлэн худалдаа, өдөрлөгт 900 иргэн, байгаль орчны тэмдэглэлт өдрүүдэд 14 арга хэмжээнд 3351 иргэн, “Орон нутагтаа оруулах бидний хувь нэмэр” дахивар ангилах уралдаанд 1000 сурагч, эцэг эх, багш нар оролцсоноор салбарын сургалт сурталчилгааны ажилд 7269 иргэн хамрагдлаа.

Сургалт сурталчилгааны ажил өмнөх жилээс 3.6 дахин их зохион байгуулснаар мод тарих, хог хаягдал ангилах ялгах, байгальд ээлтэй технологи ашиглах аж ахуйн нэгж иргэдийн тоо нэмэгдсэн.





Зорилт 3. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, бохирдол багатай ногоон хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хангах хүрээнд

3.2 дахь арга хэмжээ Чип багц төслийг хэрэгжүүлэх

Нэгдсэн Үндэсний байгууллагын Хүүхдийн Сан болон Монгол Улсын Засгийн Газрын хамтран хэрэгжүүлж буй “Эх хүүхдийн эрүүл мэндэд үзүүлэх агаарын бохирдлын нөлөөллийг бууруулах хөтөлбөр”-ийн хүрээнд монгол гэрийн дулаалга, халаалт, агаар сэлгэлтийн ЧИП багц хэрэглэх сонирхолтой айл өрхүүдийн судалгаагаар 378 өрх хүсэлт ирүүлснээс орон нутгийн төсөв болон МАК ХХК-ын санхүүжилтээр 1 багцын үнийг 66 хувийн хөнгөлөлттэй нөхцөлөөр Сайнцагаан суманд 88, Баянжаргалан суманд 30, Дэлгэрхангай суманд 30, Дэлгэрцогт суманд 2, нийт 150 өрхөд уг багцыг олгосноор нийт 214 өрхийн хэрэглээнд нэвтрүүлээд байна. Мөн энэ арга хэмжээний үеэр “Чип багц танилцуулах” өдөрлөгийг Сайнцагаан, Эрдэнэдалай суманд зохион байгуулж, нийт 330 иргэд мэдээлэл хүргэсэн.





2024 ОНЫ 01 САРЫН 19-
ний өдөр
10:00-17:00 ЦАГТ



Ид шидийн орон, Гэр
мэдээллийн төв



Дэлгэрэнгүй мэдээллийг
86911900-ээс лавлана уу



ХӨТӨЛБӨРИЙГ ЭНДЭЭС
ҮЗНЭ ҮҮ



“ЧИП БАГЦ” СУРТАЛЧЛАХ ӨДӨРЛӨГ

Тав тухтай амьдрахад тань туслах дулаалга,
халаалт, агаар сэлгэлтийн ЧИП багц

- ✓ ГАЛ ТҮЛЭХГҮЙ. НҮҮРС, ҮНС ТОРТГООС САЛНА.
- ✓ ГЭРИЙН ДОТОРХ ТЕМПЕРАТУРЫГ ХҮССЭНЭЭРЭЭ
ТОХИРУУЛЖ, ТОГТМОЛ ДУЛААН БАЙНА.
- ✱ АГААР СЭЛГЭЛТИЙН СИСТЕМЭЭР АГААРЫН СОЛИЛЦООГ
ТОГТМОЛ ХИЙНЭ.
- ✱ АМЬДРАХ ОРЧИН АЮУЛГҮЙ, ЦЭВЭР, ТАВ ТУХТАЙ БОЛНО.
- ✱ ГАЛ ТҮЛЭХЭД ЗОРИУЛДАГ ЦАГАА ХЭМНЭЖ, ӨӨРСӨДӨӨ
ЗАРЦУУЛНА.



3.3 дахь арга хэмжээ Аймгийн ерөнхий боловсролын сургуулийн дэргэдэх “Эко клубийн чуулган” зохион байгуулах

Дундговь аймгийн ерөнхий боловсролын сургуулийн дэргэдэх эко клубийн 4 дэх удаагийн чуулганыг "ӨСВӨРИЙН БАЙГАЛЬ ХАМГААЛАГЧ" уриатай дор "Их газрын чулуу" байгалийн цогцолборт зохион байгуулсан. Тус чуулганыг Аймгийн Засаг даргын тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Их газрын чулууны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа, Сум дундын ойн ангитай хамтран нийт 9 сумын 11 сургуулийн эко клубийн 104 багш, сурагчдыг хамруулсан.

Нийт 6 төрлийн өртөөчилсөн сургалт, эко хувинтай мод тарих, явган аялал хийх, од дурандах арга хэмжээнүүд зохион байгуулснаар ерөнхий боловсролын эко клубийн үйл ажиллагааг идэвхжүүлж, сургуулийн эко клубийн гишүүд өсвөрийн байгаль хамгаалагчийн эзэмших ур чадваруудыг эзэмшлээ.





Зорилт 4. Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийг хамгаалах хүрээнд

4.8 дахь арга хэмжээ Ховор болон ашиглалтад өртөмтгий амьтныг сэргээн нутагшуулах

"Монгол тарвага"-ыг хамгаалах, өсгөх үржүүлэх зорилгоор "Их газрын чулуу" байгалийн цогцолбор газарт 50 тоо толгой, Дэрэн суманд 30 тоо толгой тарвагыг нутагшуулах ажлыг мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлж, 2023 онд 50 тоо толгой тарвага нутагшуулсан бөгөөд нутагшуулсан амьтны тоо нийт 130-д хүрсэн.



Зорилт 5. Усны нөөцийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах хүрээнд


5.3 дахь арга хэмжээ буюу Төв суурин газрын ундны усны чанар стандартыг сайжруулан цэвэршүүлэх төхөөрөмжийг ус хангамжийн 1 эх үүсвэрт суурилуулах.

2024 онд Луус, Өлзийт, Дэлгэрцогт сумдын унд ахуйн усны 3 худгийн эх үүсвэрт цэвэршүүлэх төхөөрөмж шинээр суурилуулснаар нийт 9 сумын 12 худаг цэвэршүүлэх төхөөрөмжтэй болсноор төв суурин газрын хүн амын 47.5 хувь шаардлага хангасан ундны эх үүсвэрээр хангагдлаа.



ТӨВ СУУРИН ГАЗРЫН ХҮН АМЫН ШААРДЛАГА ХАНГАСАН УНДНЫ ЭХ ҮҮСВЭРЭЭР
ХАНГАГДСАН ХУВЬ

■ Цэвэршүүлсэн усаар хангагдсан хүн ам ■ Цэвэршүүлсэн усаар хангагдсан хүн ам



Зорилт 6. Ойн нөөцийг ашиглалт, хамгаалалт, “Тэрбум мод” хөдөлгөөнийг өрнүүлж, зорилтын хэрэгжилтийг хангах хүрээнд

6.3 Ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд иргэн, хувийн хэвшлийг татан оролцуулж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэн хамтарч ажиллах

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн “Дундговьго ногооруулъя” хөтөлбөр, “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-ийн хүрээнд 164 аж ахуйн нэгж, байгууллагын 2481 иргэн 181166 мод, сөөгийг тарьж 83 хувьтай ургуулж, цэнэг усалгаа хийж, нийт модны тоо 466664-д хүрэв. Өмнөх оноос 81,2 хувиар өссөн байна.



Зорилт 7. Аялал жуулчлалыг хөгжүүлэх хүрээнд

7.1 арга хэмжээ. Аялал жуулчлалын эвент арга хэмжээнүүдийг төр хувийн хэвшилтэй хамтран зохион байгуулах

Аймгийн төвд “Торгоны зам” олон улсын авто ралли уралдааны тамирчид 260 хүн оролцсон. Цагаан суварга байгалийн үзэсгэлэнт газрын “Говь каравансерай” баазтай хамтран “Персейдын солирын бороо” эвент арга хэмжээг зохион байгуулж 146 зочид төлөөлөгчид оролцсон. Сайхан-Овоо сумын Онгийн хийд байгалийн дурсгалт “Адуучны өв соёлын баяр” эвент арга хэмжээг зохион байгуулж 450 гадаад, дотоодын жуулчин оролцсон. Улаанбаатар хотод “Тансаг айраг” фестивалийг зохион байгуулж 220 хүн оролцсон. Мөн Мандалговь хотод “Говийн өнгө, Говийн залуус” арга хэмжээг зохион байгуулж, 512 дэмбээчин, 129 айраг уугч оролцож, 10000 хүн уг үйл ажиллагааг үзэж, Нийт 5 эвент үйл ажиллагаанд 11076 гадаад, дотоодын жуулчид үзэж сонирхсон.



ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Монгол Улсын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг 98.4 хувьтай буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлж, үнэлгээний саналыг хүргүүлж байна. Нийт 45 арга хэмжээ хэрэгжүүлэхээс 42 арга хэмжээ 100 хувь, 95 хувь –1, 70 хувь-1, 61.7 хувь-1 үр дүнтэй хэрэгжсэн байна.

Байгаль орчны салбарын хууль тогтоомжоор ургалт сурталчилгааны ажилд 7269 иргэн хамрагдсан нь өмнөх жилээс 3.6 дахин өссөн үзүүлэлттэй байна. Ингэснээр Мод тарих, хог хаягдал ангилах ялгах, байгальд ээлтэй технологи ашиглах аж ахуйн нэгж иргэдийн тоо нэмэгдсэн.

Аялал жуулчлалын эвент арга хэмжээнүүдийг төр хувийн хэвшилтэй хамтран зохион байгууллаа. Тус аймгийн төвд “Торгоны зам” олон улсын авто ралли уралдааны тамирчид 260 хүн оролцсон. Цагаан суварга байгалийн үзэсгэлэнт газрын “Говь каравансерай” баазтай хамтран “Персейдын солирын бороо” эвент арга хэмжээг зохион байгуулж 146 зочид төлөөлөгчид оролцсон. Сайхан-Овоо сумын Онгийн хийд байгалийн дурсгалт “Адуучны өв соёлын баяр” эвент арга хэмжээг зохион байгуулж 450 гадаад, дотоодын жуулчин оролцсон. Улаанбаатар хотод “Тансаг айраг” фестивалийг зохион байгуулж 220 хүн оролцсон. Мөн Мандалговь хотод “Говийн өнгө, Говийн залуус” арга хэмжээг зохион байгуулж, 512 дэмбээчин, 129 айраг уугч оролцож, 10000 хүн уг үйл ажиллагааг үзэж, Нийт 5 эвент үйл ажиллагаанд 11076 гадаад, дотоодын жуулчид үзэж сонирхсон.

“Дундговьго ногооруулъя” хөтөлбөр, “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-ийн хүрээнд 164 аж ахуйн нэгж, байгууллагын 2481 иргэн 181166 мод, сөөгийг тарьж 83 хувьтай ургуулж, цэнэг усалгаа хийж, нийт модны тоо 466664-д хүрч өмнөх оноос 81,2 хувиар өссөн байна.

Дээрх томоохон ажлуудыг гэрээгээр хүлээсэн арга хэмжээг хэрэгжүүлэхийн тулд улсын төсвийн 429 сая төгрөг, орон нутгийн төсвийн 518.7 сая.төгрөг, хувийн хэвшлийн 935.1 сая.төгрөг, байгаль хамгаалах сангийн 111.7 сая.төгрөг нийт 1994.5 сая төгрөгийг дээрх арга хэмжээнүүдэд зарцуулсан байна.

ТАВ. ЗӨВЛӨМЖ

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст:

1. Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулахдаа суурь түвшин, хүрэх түвшнийг судалгаа шинжилгээ болон бодлогын баримт бичгийн төлөвлөлттэй уялдуулан төлөвлөх
2. Тайланг гаргахдаа шалгуур үзүүлэлтийн дагуу хүрэх түвшинд хүрсэн эсэхийг тайлагнахаас гадна үр дүн, үр нөлөөний талаар тайлагнаж хэвших.
3. Дараа оны гэрээний төсөлд хэрэгжиж болохуйц, үр дүнтэй тодорхой ажлуудыг тусгуулахаар саналыг хүргүүлэх.

Баталгаажуулсан:

Аймгийн засаг дарга

С.Мөнхчулуун

Хянасан:

Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн

дарга

Д.Даариймаа

Тайлан бичсэн:

Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн

мэргэжилтэн

Л.Мягмармядаг